

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ:ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 17⁰⁰ цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: uvurkhangai@gazar.gov.mn цахим шуудан
- Холбоо барих утас: 99567489

ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АВАХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ: ӨВӨРХАНГАЙ

№	Байгууллага	Дотоод нэгж	Албан тушаал	Орон тоо	Албан тушаалын		Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага			
					Төрөл	Ангилал, зэрэглэл	Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР										
ГҮЙЦЭТГЭХ										
1	Өвөрхангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Барилга, хот байгуулалтын хэлтэс	Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	гүйцэтгэх	Дэс түшмэл ТЗ-9	Бакалавр ба түүнээс дээш	Барилгын материалын үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмжийн ашиглалт /071506/ Үйлдвэрлэл, боловсруулалт-д ангилагдаагүй чиглэл /0729/ Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи /073209/ Барилгын бүтээц эдлэлийн технологи /073208/	Шаардахгүй	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.